



Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн
улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын
гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайлан
/ҮАГ-НАГ/2017/04-НА/



Аймгийн хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлыг хууль, журмын дагуу зарцуулсан байна.

2017 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	4-5
Дарга, Тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг	Бүлэг 1. Батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.	6
Аудитын менежер Х.Наранцацрал	1.2. Сонгууль зохион байгуулах зардлыг СЕХ-ноос өгсөн чиглэлийн дагуу хуваарилжээ.	6-10
Ахлах аудитор Д.Ихбаяр	1.3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим суманд зөрчил гарсан байна.	10-11
Аудитор Т.Оюун-Эрдэнэ	Бүлэг 2 Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаж, хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 99078660, 88049237 дугаарын утсаар харилцана уу.	2.1. Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж тайлагнасан байна.	11-12
	2.2. Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.	12-13
Уг тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү.	Дүгнэлт	14
	Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар	15
	Тайлан баталгаажуулах тушаал	15-19
www.audit.mn	Тайлангийн хавсралтууд	20-25
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот		
2017 оны 8 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МТБ	Мэдээллийн технологийн баг
ЗБ	Зохион байгуулагч
МТ	Мэдээлэл технологи

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх.
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

Тус аудитын асуудлын шинжилгээний 1 дүгээр бүлгийн 1.1 дэх асуулт нь аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд хамааралгүй байсан тул 1.2, 1.3 дахь асуултын хүрээнд хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гаргалаа.

Àöäèòää àø èäëàñàí ø àèãóóð ¿ç¿¿ëýëò: Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль;
- ᠙ ñâèéí òóòàé òóóëü;
- Сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоол;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт;

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороод болон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Цагдаагийн газарт сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлийг хамруулав.

Аудитын арга зүй: Аудитын олон улсын стандарт, АДБОУС, Нийцлийн аудитын гарын авлага, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, нийцлийн аудитын арга зүй, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулах, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын горим арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын хугацаа, багийн бүрэлдэхүүн: Аудитыг тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг хянан удирдаж, аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал хийж, сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийг аудитын газрын бүх аудиторуудад хуваарилан гүйцэтгүүлж, нийцлийн аудитын багийн ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Т.Оюун-Эрдэнэ нэгтгэн, тайланг 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 8 дугаар сарын 06-ний өдрийг äóòòàèх хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын дүн, тайлан баталгаажуулалт: Аудитын явцад 629.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 466.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх талаар холбогдох ажилтнуудад зөвлөмж өгч, 163.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн хороо

Дундговь аймаг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд 1 тойрогтой, аймгийн сонгуулийн хороо болон 15 сумын сонгуулийн хорооны нийт 46 хэсгийн хороо, 402 ажилтантайгаар сонгуулийг зохион байгуулсан байна. /Сонгуулийн хороодод ажилласан ажилчдын судалгааг Хавсралт №1-т харуулав./

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар нэр дэвшигчдийн аль нь ч олонхын санал аваагүй тул хуулийн дагуу дахин санал хураалт явагдсан байна.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардалд улсын төсвөөс олгох санхүүжилтээс СЕХ Дундговь аймгийн сонгуулийн хороонд 207,375.4 мянган төгрөгийг хуваарилжээ.

Дээрх санхүүжилтээс 42,251.2 мянган төгрөг буюу 20.4 хувийг аймгийн сонгуулийн хороонд, 165,124.2 мянган төгрөг буюу 79.6 хувийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ.

Харин дахин санал хураалт явуулах зардалд аймгийн сонгуулийн хороонд 68,618.0 мянган төгрөгийг хуваарилж 10,529.0 мянган төгрөг буюу 15.3 хувийг аймгийн сонгуулийн хороонд, 58,089.0 мянган төгрөг буюу 84.7 хувийг сумдын сонгуулийн хороонд тус тус хуваарилжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль болон дахин санал хураалтын санхүүжилтээс нийт 9,745.3 мянган төгрөгийн үлдэгдлийг СЕХ-нд төвлөрүүлжээ.

Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс болон Цагдаагийн газар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах, дахин санал хураалт явуулах ажилд Улсын бүртгэлийн хэлтсийн төсөвт 47,250.9 мянган

төгрөг, Цагдаагийн газрын төсөвт 9,042.0 мянган төгрөгийг тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр Улсын бүртгэлийн хэлтэс 47,111.2 мянган төгрөг, Цагдаагийн газар 9,042.0 мянган төгрөгийг тайлагнажээ.

Бүлэг 1.

Батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

1.2 Сонгууль зохион байгуулах зардлыг СЕХ-ноос өгсөн чиглэлийн дагуу хуваарилжээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах ажилд 207,375.4 мянган төгрөгийн санхүүжилтийг 2 хуваан олгосон бөгөөд эхний санхүүжилтийг 79,176.0 мянган төгрөгөөр, 2 дахь санхүүжилтийг 128,199.4 мянган төгрөгөөр олгож, төсөв зарцуулах зөвлөмжийг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичиг, 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 172 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах зардлын төсвийг СЕХ-ноос хуваарилсан тул хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байлаа.

Аймгийн сонгуулийн хороо, сонгууль зохион байгуулах зардлыг сумдад хуваарилахдаа СЕХ-ноос ирүүлсэн дээрх төсвийн зарцуулалтын тайлбар, зөвлөмжүүдийг үндэслэсэн байна. /Хавсралт № 2/

Аудитын явцад СЕХ-ноос ирүүлсэн төсөв зарцуулах зөвлөмжийн дагуу сонгуулийн хорооны гишүүдийн хоол, урамшууллын зардлын гүйцэтгэлийг давтан тооцоолоход зөрүү гараагүй.

Аймагт хуваарилагдсан нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх зардлын гүйцэтгэл 82.0 хувь, саналын хуудас хүргэх зардлын гүйцэтгэл 76.7 хувь, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал 79.1 хувь, болзошгүй зардлын гүйцэтгэл 28.2 хувьтай байна. Хавсралт №3 /Хүснэгт № 1.1-ийн 2, 11,12, 15 дугаар мөр/

Хүснэгт 1.1 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
---	-------------	-------	-----------	----------	-------------------

1	Сургалтын зардал	10,146.0	10,125.2	20.8	99.8%
2	Тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх	250.0	205.6	44.45	82.2%
3	Бичиг хэргийн зардал	12,080.0	12,081.4	(1.42)	100%
4	Шуудан холбоо	11,930.0	11,925.2	4.79	99.96%
5	Унааны зардал	24,350.0	23,839.0	511.01	97.9%
6	Саналын хуудас устгах	595.0	595.0		100.0%
7	Сурталчилгааны зардал	9,500.0	9,498.5	1.50	99.98%
8	Сурталчилгааны материал хүргэх зардал	1,875.0	1,804.7	70.29	96.3%
9	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	9,200.0	9,199.6	0.40	99.996%
10	Саналын хуудас хүргэх	4,300.0	3,300.0	1,000.00	76.7%
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	8,052.0	6,366.9	1,685.06	79.1%
12	МТБ-н мэдээ дамжуулах зардал	1,575.0	1,500.0	75.00	95.2%
13	Томилолтын зардал	3,746.0	3,673.0	73.00	98.1%
14	Эрчим хүчний эх үүсвэр	1,932.0	1,932.0		100.0%
15	Болзошгүй зардал	3,000.0	845.0	2,155.00	28.2%
16	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	87,320.0	87,320.0		100.0%
17	МТБ-н гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	17,524.4	17,524.4		100.0%
	Дүн	207,375.4	201,735.5	5,639.9	

Харин аймгийн Сонгуулийн хороонд хуваарилагдсан нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх зардлын гүйцэтгэл 37.0 хувь, саналын хуудас хүргэх зардлын гүйцэтгэл 76.7 хувь, унааны зардлын гүйцэтгэл 88.0 хувь, санал хүргэх зардлын гүйцэтгэл 76.7 хувь, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал 68.3 хувьтай байна. /Хүснэгт № 1.2-ийн 2, 10, 11 дүгээр мөр/

Хүснэгт 1.2 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Гүйцэтгэлийн хувь
1	Сургалтын зардал	10,146.0	10,125.2	20.8	99.8%
2	Тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх	70.0	25.6	44.4	37%
3	Бичиг хэргийн зардал	800.0	792.9	7.1	99.1%
4	Шуудан холбоо	1,400.0	1,395.2	4.8	99.7%
5	Унааны зардал	4,310.0	3,800.0	510.0	88%
6	Саналын хуудас устгах	595.0	595.0	-	100%
7	Сурталчилгааны зардал	6,000.0	5,998.5	1.5	99.98%
8	Сурталчилгааны материал хүргэх зардал	600.0	599.7	0.3	99.95%
9	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	1,334.0	1,334.0	-	100%
10	Саналын хуудас хүргэх	4,300.0	3,300.0	1,000.0	76.7%
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	5,278.0	3,602.9	1,675.1	68.3%
12	МТБ-н мэдээ дамжуулах зардал	675.0	600.0	75.0	88.9%
13	Томилолтын зардал	834.0	761.0	73.0	91.2%

14	Эрчим хүчний эх үүсвэр	-	-	-	
15	Болзошгүй зардал	-	-	-	
16	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	4,269.2	4,269.2	-	100%
17	МТБ-н гишүүн ,даамлын урамшуулал, хоолны зардал	1,640.0	1,640.0	-	100%
	Дүн	42,251.2	38,839.2	3,412.0	

Хуваарилсан төсөв нийт дүнгээр 5,639.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд үүнээс 3,412.0 мянган төгрөг буюу 60.5 хувь нь аймгийн Сонгуулийн хорооны зардлаас, 2,227.9 мянган төгрөг буюу 39.5 хувь нь сумдын сонгууль зохион байгуулах зардлаас тус тус хэмнэгдсэн байна.

Энэ нь саналын хуудас хүргэх, санал тоолох төхөөрөмж хүргэх ажлыг тухайн үеийн ажлын шаардлага цаг хугацаанаас шалтгаалж нэг удаагийн явалтаар хүргэж өгсөн, сумдаас ирсэн саналыг үндэслэн төсөв хоорондын зохицуулалт хийлгэсэн боловч гүйцэтгэл гараагүй зэрэгтэй холбоотой байна.

Харин дахин санал хураалт явуулах зардалд аймгийн Сонгуулийн хороонд 68,618.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 2 хуваан олгосон бөгөөд эхний санхүүжилтийг 28,418.0 мянган төгрөгөөр, 2 дахь санхүүжилтийг 40,200.0 мянган төгрөгөөр олгож, төсөв зарцуулах зөвлөмжийг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 260 дугаар албан бичиг, 2017 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 295 дугаар албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

Аймагт хуваарилагдсан нийт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад саналын хуудас хүргэх зардлын гүйцэтгэл 34.4 хувь, санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал 91.8 хувь, МТБ-ын мэдээ дамжуулах зардал зардлын гүйцэтгэл 67.7 хувьтай байна. /Хүснэгт № 1.3-ийн 4, 5, 6 дугаар мөр/

Хүснэгт 1.3 /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэг-дэл	Гүйцэтгэл-ийн хувь
1	Бичиг хэргийн зардал	1,090.0	1,090.0		100%
2	Шуудан холбоо	1,320.0	1,320.0		100%
3	Унааны зардал	2,925.0	2,925.0		100%
4	Саналын хуудас хүргэх	4,300.0	1,480.0	2,82	34.4%
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	6,526.0	5,990.6	535.0	91.8%
6	МТБ-н мэдээ дамжуулах зардал	2,325.0	1,575.0	750.0	67.7%
7	Эрчим хүчний эх үүсвэр	1,932.0	1,932.0		100%
8	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-н гишүүн, даамлын хоолны зардал	8,000.0	8,000.0		100%
9	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-н гишүүн, даамлын урамшуулалын зардал	40,200.0	40,200.0		100%

	Дүн	68,618.0	64,512.6	4,105.4	
--	------------	-----------------	-----------------	----------------	--

Дахин санал хураалт явуулах зардлын төсөв нийт дүнгээр 4,105.4 мянган төгрөгөөр хэмнэгдсэн ба энэ нь аймгийн сонгуулийн хорооны зардлаас хэмнэгджээ.

Дахин санал хураалт явуулах үед аймгийн Сонгуулийн хороо саналын хуудас хүргэх, санал тоолох төхөөрөмж хүргэх ажлыг нэг удаагийн явалтаар олгосон, МТБ-н мэдээ дамжуулах зардлын төсөв бүх санал авах байранд хуваарилагдсан боловч СЕХ-ны төсөв хуваарилах зааврын дагуу хөдөөгийн багт хуваарилахаар зааж өгсөн зэргээс шалтгаалж төсөв нь хэмнэгджээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар хуулийн 23.3-т заасны дагуу 46 хэсгийн хороотой үйл ажиллагаа явуулжээ. /Хүснэгт 1.4/

Хүснэгт 1.4

№	Тойргийн нэр	1 хэсгийн хороонд санал өгөх сонгогчийн тоо	Сонгуулийн насны хүн ам	Хэсгийн хорооны тоо
1	Адаацаг	365	1827	5
2	Баянжаргалан	759	759	1
3	Говь-Угтаал	1034	1034	1
4	Гурвансайхан	471	1413	3
5	Дэлгэрхангай	721	1441	2
6	Дэлгэрцогт	1084	1084	1
7	Дэрэн	338	1353	4
8	Луус	592	1183	2
9	Сайнцагаан 1	459	459	1
10	Сайнцагаан 2	537	537	1
11	Сайнцагаан 3	616	616	1
12	Сайнцагаан 4	500	500	1
13	Сайнцагаан 5	1203	1203	1
14	Сайнцагаан 6	1250	1250	1
15	Сайнцагаан 7	2219	2219	1
16	Сайнцагаан 8	1363	1363	1
17	Сайнцагаан 9	1649	1649	1
18	Сайхан-Овоо	462	1387	3
19	Хулд	779	1558	2
20	Цагаандэлгэр	667	667	1
21	Эрдэнэдалай	518	3628	7
22	Өлзийт	534	1601	3
23	Өндөршил	477	953	2
	Дүн		29684	46

Сонгуулийн тухай хуулийн 38.2-т УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн улсын төсвөөс санхүүжих 19 нэр төрлийн зардлын ангиллыг заасан.

Үүнээс Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой аймгуудын сонгуулийн хороонд хуваарилах зардлыг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-д тусгасан боловч СЕХ-оос төсөв хуваарилахдаа журамд тусгагдаагүй дараах зардлуудыг хуваарилжээ. Үүнд:

1. Сурталчилгааны зардал;
2. Сурталчилгааны материал хүргэх зардал;
3. Саналын хуудас устгах зардал;
4. Эрчим хүчний эх үүсвэр;
5. Болзошгүй зардал.

Дээрх зардлууд нь журамд тусгагдаагүй боловч Сонгуулийн тухай хуульд нийцэж байна. /Сонгуулийн тухай хууль, Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам, Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан зардлын зүйлийг харьцуулсан үзүүлэлтийг Хавсралт №-4 т орууллаа./

Мөн тус журамд сумдын сонгуулийн хороонд хуваарилах 6 нэр төрлийн зардлыг заасан боловч Дундговь аймгийн хувьд СЕХ-оос ирүүлсэн зөвлөмжийн дагуу зардлыг хуваарилж, гүйцэтгэлийг тайлагнажээ.

Дээрх байдлаас харахад Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам" нь Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй, тодорхой бус байгаагаас хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тиймээс тус журмын 2.2, 2.3 дахь заалтуудыг Сонгуулийн тухай хуульд нийцүүлэх талаар Үндэсний аудитын газраар дамжуулан СЕХ-нд уламжлах саналтай байна.

1.3 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим суманд зөрчил гарсан байна.

Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд аудит хийх явцад сонгуулийн зардлыг батлагдсан хэмжээнд зарцуулсан хэдий ч нийт 569.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Дэлгэрцогт, Хулд, Эрдэнэдалай сумдын сонгуулийн хороо сонгуулийн болзошгүй зардлаас 618.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.
- Сайнцагаан сумын сонгуулийн хороо бичиг хэргийн зардлын төсвийг 9.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, МТ-ийн даамал техник хэрэгслийг МТБ-т хүлээлгэн өгөх зардлаас зарцуулсан.
- Эрдэнэдалай сумын сонгуулийн хороо Бичиг хэргийн зардлын төсвийг 1.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, МТ-ийн даамал техник хэрэгслийг МТБ-т хүлээлгэн өгөх зардлаас зарцуулсан.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д */батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/*, Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйл 38.2.-т */Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын сонгуулийн доор дурдсан сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:/*, 38.2.16-д */онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;/*, Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, түүнд хяналт тавих тайлан гаргах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.-д */Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна;/*, 3.1.5.-д */“онцгой нөхцөл байдал үүссэн” гэж сонгуулийг зохих ёсоор явуулахад урьдчилан төлөвлөөгүй, төлөвлөх боломжгүй нэмэлт зардал, хөрөнгө зарцуулах зайлшгүй шаардлага бий болсныг;/*, 3.2.-т */Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ;/*, Сонгуулийн ерөнхий хорооны 2017.06.13-ны өдрийн "Сонгуулийн зардлын тухай" 199 дугаар албан бичигт, *Болзошгүй зардал: /Байгалийн гэнэтийн аюул, цаг агаарын нөхцөл байдлаас гол ус үерлэх, зам хаагдах, холбоо тасрах тохиолдолд онцгой байдлын зориулалтаар хэрэглэнэ;/* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Гарсан зөрчлүүдийг арилгах, дахин гаргахгүй байх талаар холбогдох ажилтнуудад аудитын явцад 466.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 163.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Дээрх зөрчлүүд нь 2016 оны ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитаар гарч байсан бөгөөд аймаг, сумын сонгуулийн хороо байнгын бус үйл ажиллагаатай байдаг тул сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлагналын дараахь үе шатны ажил, аудитын мөрөөр авах арга хэмжээний биелэлтийг тооцох боломжгүй байгааг харуулж байна.

Бүлэг 2.

Сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнаж, хяналтыг журмын дагуу хэрэгжүүлсэн байна.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 113 дугаар албан бичгээр МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардал болон дахин санал хураалт зохион байгуулах зардлын тайланг хуваарилсан төсвийн дагуу тус тусад нь гаргах, мөн архивын баримтыг нь тус тусад нь архивын боть болгон бэлтгэхээр зааварлажээ.

Аймаг, сумын сонгуулийн хороод сонгууль зохион байгуулах зардлыг СЕХ-ноос өгсөн заавар, чиглэлийн дагуу тайлагнасан бөгөөд сонгууль зохион байгуулах зардлыг нийт 275,933.4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 266,248.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй, 9,745.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж, үлдэгдлийг СЕХ-нд төвлөрүүлсэн байна. /Хавсралт №5, 6, Хүснэгт 2.1/

Хүснэгт 2.1 /мянган төгрөгөөр /

№	Сонгууль	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Буцаан төвлөрүүлсэн
1	МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардал	68,618.0	64,512.6	4,105.4	4,105.4
2	МУ-ын Ерөнхийлөгчийн дахин санал хураалтын зардал	207,375.4	201,735.5	5,639.9	5,639.9
	Дүн	275,993.4	266,248.1	9,745.3	9,745.3

Аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 4.4¹-т заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг СЕХ-нд хүргүүлсэн байна.

¹ /Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд тус тус хүлээлгэж өгнө./

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулах үеэр нийт 10 нэр төрлийн 503.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, тэдгээрийг УСНББОУС 12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т */Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ./* заасны дагуу сонгуулийн хэсгийн хороод байрлаж байсан байгууллагад бүртгэжээ.

2.2 Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад журмын дагуу хяналт тавьж ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын 3.4-т */Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина./* заасны дагуу аймгийн сонгуулийн хороо дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

- Сумын сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, нягтлан бодогч нарт төсвийг зориулалтын дагуу хяналттай зарцуулах, тайлагнах, анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар 2 удаа сургалт зохион байгуулж, өмнөх оны сонгуулийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөсөн;
- "Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам"-ын хүрээнд сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын талаар тайлбар, зөвлөмж гаргаж сумдын хэсгийн хороодод хүргүүлсэн;
- Аймгийн сонгуулийн хорооны даргын баталсан, сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалт болон бусад үйл ажиллагааны явцад хяналт тавих удирдамжийн хүрээнд аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч 10 суманд ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад журмын дагуу хяналт тавьж ажилласан боловч Сайнцагаан, Дэлгэрцогт, Хулд, Эрдэнэдалай сумд төсвийн зарцуулалттай холбоотой зөрчил гаргасан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Сонгууль зохион байгуулах зардлыг СЕХ-ноос өгсөн чиглэлийн дагуу хуваарилжээ;
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч зарим суманд зөрчил гарсан байна;
3. Сонгуулийн зардлын бүртгэлийг журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна;
4. Аймгийн сонгуулийн хорооноос сонгуулийн зардлын зарцуулалтад журмын дагуу хяналт тавьж ажилласан байна;

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГЭХ САНАЛ

1. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.2, 2.3 дахь заалтуудыг Сонгуулийн тухай хуульд нийцүүлэх.

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ИХБАЯР

ТАЙЛАНГ ХЯНАСАН :

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/17

Мандагловь

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын хавсралтын 5 дугаар заалт, Нийцлийн аудитын түр журмын 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Үндэсний Аудитын газрын нэгдсэн удирдамж, хөтөлбөрийн дагуу "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайлан (YAГ-НАГ/2017/04-НА) -г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт, актын төлбөр, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Нийцлийн аудитын тайланг Үндэсний Аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сонгуулийн хороонд тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сонгуулийн хороонд зөвлөсүгэй.
5. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, нийцлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Ихбаяр/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ТӨРӨУНЧИМЭГ



D:\office\tushaal\A4\Songuuli-r.docx

Аой аа ау аеі аг дахь Төрийн аоаеòòí äàçðùí тэргүүлэх аоаеòòí ðùí 2017 í í ù 08 äугаар ñàðùí 10 - í ù °äðèéí А/17 дугаар ооø ààèùí 1 ä¿ãýýð оàãñòàèò

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Аудитын код: **ҮАГ-НАГ/2017/04-НА**

Аудитын нэр: **“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл”**

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн мян.төг	Үүнээс				°ð°æèí ä¿ðòäýèä	
				Аудитын явцад барагдуулсан	Акт тавигдсан	Албан шаардлага	Зөвлөмжөөр өгсөн	òíí	í°íæí ä¿
1	Дэлгэрцогт сумын сонгуулийн хороо болзошгүй зардлыг зориулалт бусаар зарцуулсан.	Сонгуулийн тухай хуулийн Сонгуулийн тухай хуулийн 34.1.6.-д /улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих/, 38.2.18-д /онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;/, 3.1.5-д /онцгой нөхцөл байдал үүссэн” гэж сонгуулийг зохих ёсоор явуулахад урьдчилан төлөвлөөгүй, төлөвлөх боломжгүй нэмэлт зардал, хөрөнгө зарцуулах зайлшгүй шаардлага бий болсныг	65.0		65.0			1	65.0

2	Хулд сумын сонгуулийн хороо болзошгүй зардлыг зориулалт бус зүйлд зарцуулсан.	Сонгуулийн тухай хуулийн Сонгуулийн тухай хуулийн 34.1.6.-д /улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих/, 38.2.18-д /онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;/, 3.1.5-д /"онцгой нөхцөл байдал үүссэн" гэж сонгуулийг зохих ёсоор явуулахад урьдчилан төлөвлөөгүй, төлөвлөх боломжгүй нэмэлт зардал, хөрөнгө зарцуулах зайлшгүй шаардлага бий болсныг	98.0		98.0			1	98.0
3	Сайнцагаан сумын сонгуулийн хороо бичиг хэргийн зардлын төсвийг 9.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, МТ-ийн даамал техник хэрэгслийг МТБ-т хүлээлгэн өгөх зардлаас зарцуулсан.	Монгол улсын сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичигт /Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо хуваарилсан төвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсэн болно/	9.6				9.6		
4	Эрдэнэдалай сумын сонгуулийн хороо бичиг хэргийн зардлын төсвийг 1.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, МТ-ийн даамал техник хэрэгслийг МТБ-т хүлээлгэн өгөх зардлаас зарцуулсан.	Монгол улсын сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичигт /Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо хуваарилсан төвийг зүйл анги хооронд нь шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар хэрэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсэн болно/	1.4				1.4		

5	Эрдэнэдалай сумын сонгуулийн хороо болзошгүй зардлаас 7 галын хорыг худалдан авч ЗДТГ-ын дансанд орлого авсан.	Сонгуулийн тухай хуулийн 34.1.6.-д /улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих/, 38.2.18-д /онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;/, 3.1.5-д /"онцгой нөхцөл байдал үүссэн" гэж сонгуулийг зохих ёсоор явуулахад урьдчилан төлөвлөөгүй, төлөвлөх боломжгүй нэмэлт зардал, хөрөнгө зарцуулах зайлшгүй шаардлага бий болсныг	455.0				455.0	1	455.0
	Дүн		629.0	-	163.0	-	466.0	3	618.0

АУДИТЫН ГАЗАР

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

Дундговь аймгийн Ерөнхийлөгчийн сонгуулийн салбар болон хэсгийн хороодод ажилласан ажилчдын судалгаа

№	Сумдын нэр	Хэсгийн хорооны тоо	Дарга	СХ-ны нарийн бичгийн дарга	СХ-ны гишүүд	Ахлах зохион байгуулагч	Зохион байгуулагч	Даамлын багийн гишүүд	Мэдээлэл технологийн багийн гишүүд	Гэрээт ажилтан /Бичиг хэрэг, нягтлан бодогч /	Бүгд / Хүний тоо /
1	Өлзийт	3	1	1	3	3	12	4			24
2	Хулд	2	1	1	3	2	12	3			22
3	Луус	2	1	1	3	2	8	3			18
4	Дэлгэрхангай	2	1	1	3	2	8	3			18
5	Сайхан-Овоо	3	1	1	3	3	12	4			24
6	Эрдэнэдалай	7	1	1	3	7	30	8			50
7	Адаацаг	5	1	1	3	5	20	6			36
8	Дэлгэрцогт	1	1	1	3	1	6	2			14
9	Дэрэн	4	1	1	3	4	16	5			30
10	Цагаандэлгэр	1	1	1	3	1	4	2			12
11	Говь-Угтаал	1	1	1	3	1	6	2			14
12	Баянжаргалан	1	1	1	3	1	4	2			12
13	Өндөршил	2	1	1	3	2	8	3			18
14	Гурвансайхан	3	1	1	3	3	12	4			24
15	Сайнцагаан	9	1	1	5	9	46	10			72
16	Аймгийн төв		1	1	5				5	2	14
Нийт		46	16	16	52	46	204	61			402

Хавсралт №2

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлыг сумын сонгуулийн хороодоор хуваарилсан товчоо

д/д	Хороодын нэр	Санал авах байрны тоо	Зардлын төрөл										Эрчим хүчний эх үүсвэр	Болзошгүй зардал	Мэдээ дамжуулах зардал	Томилолтын зардал	Сонгуудийн байгууллагын ажилтнуудын урамшуулал, хоолны зардал	МТБ-н гишүүн, даамлын урамшуулал, хоол	Зардлын дүн	
			Сургалтын зардал	Тогтоол, протокол, маягт хэвлүүлэх	Саналын хуудас устгах	Бичиг хэргийн зардал	Шуудан холбоо	Унааны зардал	Хууль тогтоомж сурталчлах зардал	Сурталчилгааны материал хүргэх	Санал авах байр бэлтгэх	сумдад саналын хуудас хүргэх унаа, томилголт								Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал
1	Аймгийн сонгуулийн хороо		10146.0	70.0	595.0	800.0	1400.0	4310.0	6000.0	600.0	1334.0	4300.0	5278.0			675.0	834.0	4269.2	1640.0	42251.2
2	Дэлгэрцогт	1		12.0		380.0	330.0	700.0	200.0	70.0	171.0		113.0	42.0	65.0		160.0	3115.2	520.8	5879.0
3	Дэрэн	4		12.0		920.0	870.0	1600.0	200.0	70.0	684.0		167.0	168.0	260.0	150.0	196.0	6318.8	1302.0	12917.8
4	Говь-Угтаал	1		12.0		380.0	330.0	700.0	200.0	70.0	171.0		178.0	42.0	65.0		225.0	3115.2	520.8	6009.0
5	Цагаандэлгэр	1		12.0		380.0	330.0	700.0	200.0	70.0	171.0		208.0	42.0	65.0		255.0	2631.2	520.8	5585.0
6	Баянжаргалан	1		12.0		380.0	330.0	700.0	200.0	70.0	171.0		218.0	42.0	65.0		225.0	2631.2	520.8	5565.0
7	Өндөршил	2		12.0		560.0	510.0	1000.0	200.0	100.0	342.0		260.0	84.0	130.0		305.0	3860.4	781.2	8144.6
8	Гурвансайхан	3		12.0		740.0	690.0	1300.0	200.0	100.0	513.0		138.0	126.0	195.0		185.0	5089.6	1041.6	10330.2
9	Өлзийт	3		12.0		740.0	690.0	1540.0	200.0	100.0	513.0		158.0	126.0	195.0	75.0	205.0	5089.6	1041.6	10685.2
10	Хулд	2		12.0		560.0	510.0	1000.0	200.0	70.0	342.0		150.0	84.0	130.0		150.0	4828.4	781.2	8817.6
11	Луус	2		12.0		560.0	510.0	1000.0	200.0	70.0	342.0		113.0	84.0	130.0		115.0	3860.4	781.2	7777.6
12	Дэлгэрхангай	2		12.0		560.0	510.0	1000.0	200.0	70.0	342.0		198.0	84.0	130.0		198.0	3860.4	781.2	7945.6
13	Сайхан-Овоо	3		12.0		740.0	690.0	1300.0	200.0	75.0	513.0		260.0	126.0	195.0	75.0	260.0	5089.6	1041.6	10577.2
14	Эрдэнэдалай	7		12.0		1460.0	1410.0	2500.0	300.0	120.0	1197.0		236.0	294.0	455.0	375.0	236.0	10567.2	2083.2	21245.4
15	Сайнцагаан	9		12.0		1820.0	1770.0	3100.0	600.0	120.0	1539.0		180.0	378.0	595.0			15445.6	2604.0	28163.6
16	Адаацаг	5		12.0		1100.0	1050.0	1900.0	200.0	100.0	855.0		197.0	210.0	325.0	225.0	197.0	7548.0	1562.4	15481.4
	ДҮН	46	10146.0	250.0	595.0	12080.0	11930.0	24350.0	9500.0	1875.0	9200.0	4300.0	8052.0	1932.0	3000.0	1575.0	3746.0	87320.0	17524.4	207375.4

Хавсралт №3

МУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

д/д	Хороодын нэр	Зардлын төрөл						Эрчим хүчний эх үүсвэр	Болзошгүй зардал	Мэдээ дамжуулах	Сурталчилгааны материал хүргэх	Мөнгөн урамшуулал, хоол		Томиллолт		Зардлын дүн	Дансны үлдэгдэл
		Бичиг хэргийн зардал	Маягт хэвлүүлэх	Шуудан холбоо	Унааны зардал	Хууль тогтоомж сурталчлах зардал	Санал авах байрны бэлтгэх зардал					Сонгуудийн ажилт-нуудын урамшуулал, хоолны зардал	санал авах байрны даамлын урамшуулал	Сумын СХ-оос АСХ-д дүн мэдээ хүргэх	МТ-н даамал хэрэгслийг хүлээлгэн өгөх томиллолт унаа		
1	Дэлгэрцогт	380	12	330	700	200	171	42	65	0	70	3115.2	520.8	160	113.0	5879.0	0.0
2	Дэрэн	920	12	870	1600	200	684	168	0	150	70	6318.8	1302	196	167.0	12657.8	260.0
3	Говь-Угтаал	380	12	330	699.2	200	171	42	0	0	70	3115.2	520.8	225	178.0	5943.2	65.8
4	Цагаандэлгэр	380	12	330	700	200	171	42	0	0	70	2631.2	520.8	255	208.0	5520.0	65.0
5	Баянжаргалан	379.65	12	330	700	200	170.6	42	0	0	70	2631.2	520.8	225	218.0	5499.3	65.8
6	Өндөршил	560	12	510	1000	200	342	84	0	0	100	3860.4	781.2	305	260.0	8014.6	130.0
7	Гурвансайхан	740	12	690	1300	200	513	126	0	0	100	5089.6	1041.6	185	138.0	10135.2	195.0
8	Өлзийт	739.25	12	690	1540	200	513	126	0	75	100	5089.6	1041.6	205	158.0	10489.5	195.8
9	Хулд	560	12	510	1000	200	342	84	130	0	70	4828.4	781.2	150	150.0	8817.6	0.0
10	Луус	560	12	510	1000	200	342	84	0	0	70	3860.4	781.2	115	113.0	7647.6	130.0
11	Дэлгэрхангай	560	12	510	1000	200	342	84	0	0	0	3860.4	781.2	198	198.0	7745.6	200.0
12	Сайхан-Овоо	740	12	690	1300	200	513	126	195	75	75	5089.6	1041.6	260	260.0	10577.2	0.0
13	Эрдэнэдалай	1460	12	1410	2500	300	1197	294	455	375	120	10567.2	2083.2	236	236.0	21245.4	0.0
14	Сайнцагаан	1829.61	12	1770	3099.8	600	1539	378	0	0	120	15445.6	2604	0	170.0	27568.0	595.6
15	Адаацаг	1100	12	1050	1900	200	855	210	0	225	100	7548	1562.4	197	197.0	15156.4	325.0
ДҮН		11288.5	180.0	10530.0	20039.0	3500.0	7865.6	1932.0	845.0	900.0	1205.0	83050.8	15884.4	2912.0	2764.0	162896.3	2227.9

Хавсралт № 4

Сонгуулийн тухай хуульд улсын төсвөөс санхүүжих зардлын зүйл	Сонгуулийн Ерөнхий Хорооноос хуваарилсан зардлын зүйл
38.2.4.саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал;	Саналын хуудас устгах, хүргэх зардал
38.2.6.тамга, тэмдэг, лац, саналын хуудас битүүмжлэн хадгалах уут бэлтгэх зардал;	
38.2.10.сонгуулийн хууль тогтоомж болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, хэвлэх, хүргэх зардал;	Сурталчилгааны зардал Сурталчилгааны материал хүргэх зардал
38.2.12.сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах болон сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;	
8.2.18.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;	Болзошгүй зардал , Эрчим хүчний эх үүсвэр



Сонгуулийн тухай хуульд улсын төсвөөс санхүүжихээр заасан боловч журамд аймгийн сонгуулийн хороодод хуваарилах зардалд ороогүй зардлууд.



Сонгуулийн Ерөнхий Хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан зардлаас журамд заагдаагүй зардлууд.

Хавсралт №5

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн төсвийн зарцуулалтын нэгдсэн тайлан

№	Зардлын нэр	Үйлчлүүлэгчийн тайлангаар			Аудитаар залруулсан			Аудитаар баталгаажуулсан		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал	10,146.0	10,125.2	20.8				10,146.0	10,125.2	20.8
2	Тогтоол, протокол, маягт, материал хэвлүүлэх	250.0	205.6	44.5				250.0	205.6	44.5
3	Бичиг хэргийн зардал	12,080.0	12,081.4	(1.4)				12,080.0	12,081.4	(1.4)
4	Шуудан холбоо	11,930.0	11,925.2	4.8				11,930.0	11,925.2	4.8
5	Унааны зардал	24,350.0	23,839.0	511.0				24,350.0	23,839.0	511.0
6	Саналын хуудас устгах	595.0	595.0					595.0	595.0	
7	Сурталчилгааны зардал	9,500.0	9,498.5	1.5				9,500.0	9,498.5	1.5
8	Сурталчилгааны материал хүргэх зардал	1,875.0	1,804.7	70.3				1,875.0	1,804.7	70.3
9	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	9,200.0	9,199.6	0.4				9,200.0	9,199.6	0.4
10	Саналын хуудас хүргэх	4,300.0	3,300.0	1,000.0				4,300.0	3,300.0	1,000.0
11	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	8,052.0	6,366.9	1,685.1				8,052.0	6,366.9	1,685.1
12	МТБ-н мэдээ дамжуулах зардал	1,575.0	1,500.0	75.0				1,575.0	1,500.0	75.0
13	Томилолтын зардал	3,746.0	3,673.0	73.0				3,746.0	3,673.0	73.0
14	Эрчим хүчний эх үүсвэр	1,932.0	1,932.0					1,932.0	1,932.0	
15	Болзошгүй зардал	3,000.0	845.0	2,155.0				3,000.0	845.0	2,155.0
16	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	87,320.0	87,320.0					87,320.0	87,320.0	
17	МТБ-н гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	17,524.4	17,524.4					17,524.4	17,524.4	
18	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,639.9	(5,639.9)				-	5,639.9	(5,639.9)
	Дүн	207,375.4	207,375.4					207,375.4	207,375.4	-

Хавсралт №6

МУ-ын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн дахин санал хураалтын төсвийн зарцуулалтын нэгдсэн тайлан

№	Зардлын нэр	Үйлчлүүлэгчийн тайлангаар			Аудитаар залруулсан			Аудитаар баталгаажуулсан		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Бичиг хэргийн зардал	1,090.0	1,090.0					1,090.0	1,090.0	
2	Шуудан холбоо	1,320.0	1,320.0					1,320.0	1,320.0	
3	Унааны зардал	2,925.0	2,925.0					2,925.0	2,925.0	
4	Саналын хуудас хүргэх	4,300.0	1,480.0	2,820.0				4,300.0	1,480.0	2,820.0
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	6,526.0	5,990.6	535.4				6,526.0	5,990.6	535.4
6	МТБ-н мэдээ дамжуулах зардал	2,325.0	1,575.0	750.0				2,325.0	1,575.0	750.0
7	Эрчим хүчний эх үүсвэр	1,932.0	1,932.0					1,932.0	1,932.0	
8	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-н гишүүн, даамлын хоолны зардал	8,000.0	8,000.0					8,000.0	8,000.0	
9	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-н гишүүн, даамлын урамшуулалын зардал	40,200.0	40,200.0					40,200.0	40,200.0	
10	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,105.4	(4,105)					4,105.4	(4,105.4)
		68,618.0	68,618.0					68,618.0	68,618.0	